



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 4/09

Жаргалант сум

**᠒** Электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг  
худалдан борлуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2.2 дахь заалт, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7, 6.7.14 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2023 оны А/268 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглосугай.

2.Өсвөр насны хүүхдүүдийн электрон тамхины хэрэглээ, хүний эрүүл мэнд, амь насанд аюул, эрсдэл учруулах, никотоны дадал, тамхинд донтох явдлыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор 21 нас хүрээгүй хүнд утаат тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулах, Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн дотор утаат тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглосугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүүхэд хамгааллын хамтарсан баг, Нийгмийн бодлогын мэргэжилтэн (С.Болоржаргал), Жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Г.Даваажаргал), Цагдаагийн тасгийн дарга, Хошууч (Ч.Энхбат) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 10 сарын 20-ны өдрийн А/109 тоот захирамжийг хүчингүйд тооцугай.

5.Захирамжийн хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Амартүвшин) –д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.АМАРБАЯСГАЛАН

